



МОНГОЛ УЛСЫН  
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн  
зээл төлөлтийн тухай

Монгол Улсын Иргэний хуулийн 15 дугаар бүлгийн 180,181,183,184 дүгээр зүйл, Засгийн газрын 1997 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшигчдэд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох журам"-ын 13,14,16,17 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаад дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн анхан, дунд шатны сургууль болон магистрантур төгсөгчид сургалтын төлбөрийн зээлээ цалингаасаа тодорхой хэмжээгээр эргүүлэн төлж байгаа бол төгсөгчийн дипломыг түүний ажил эрхэлж байгаа үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж байхыг Сургалтын төрийн сан \Б.Ганбат\ -д даалгасугай.

2. Төгсөгч ажил эрхлээгүй тохиолдолд сургалтын төлбөрийн зээлээ эргүүлэн төлөхөд зориулж анз, барьцаа, дэнчин, батлан даалтын аль нэгийг зээлдэгчээс гаргуулах, түүнтэй холбогдон гарах маргаантай асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлж байхыг Сургалтын төрийн сан \Б.Ганбат\ -д үүрэг болгосугай.



САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБИЛЭГ